

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.18

Онцлох мэдээ

- Япон улсын голлох хэрэглээний үнийн индекс өнгөрсөн сард 5 сар дараалан өссөн боловч хурд нь саарчээ. Түүнчлэн тус улсын төв банк бусад орнуудтай харьцуулахад бодлогын хүүгээ хоцорч өсгөнө гэсэн магадлалыг нэмэгдүүллээ. ХҮИ 0.2% өссөн боловч түүний өмнөх 2 сард 0.5% өсөөд байсан юм.
- Орос-Украины хямралын үеэр АНУ-ын холбооны агентлагуудын үйл ажиллагаагаа зогсооход тулаад байгаа ичгүүртэй үзэгдлээсээ зайлсхийж, Конгрессоос засгийн газрыг 3-р сарын 11-нийг хүртэл санхүүжүүлэх хуулийн төслийг эцэслэн баталлаа.

Валютын зах зээл

Украины асуудлаар хэлэлцэж буй АНУ-ОХУ хоорондын ярианаас зах зээл бага зэрэг тайвширч эрсдэл багатай иен энэ долоо хоногийн эхээр олоод байсан ашгаа буцаав. Харин Австрали доллар гэх мэт эрсдэлд мэдрэг хөрөнгүүд өслөө. Ам.долларын ханш иений эсрэг 114.78 хүрч буураад байсны дараа 0.2% чангарч дээш 115.27 хүртэл чангарав. Иентэй өрсөлдөгч Швейцар франк энэ долоо хоногт Украины хурцадмал байдлын үеэр чангараад байсан ч өнөөдөр ам.долларын эсрэг 0.12% суларлаа. Австрали долларын ханш 0.27% өсжээ. Еврогийн тухайд энэ долоо хоногт хэлбэлзэл ихтэй хөдөлгөөн үргэлжилж, сүүлд 1.1365-тай тэнцсэн бол Английн төв банкны бодлогын таамаглалаар фунтийн ханш өсөж 1.3605 хүрээд байна.

Алтны зах зээл

Баасан гарагт алтны ханш 2021 оны 6 сараас хойш хамгийн дээд түвшинд хүрээд байна. Шалтгаан нь буурч байгаа АНУ-ын засгийн бондын өгөөж болон Орос Баруун хоорондын зөрчилдөөн болоод байна. 1 унц алтны спот ханш өглөө 0.3% өсөлттэй 1,902.20 ам.доллар байлаа. АНУ-ын алтны фьючерс 0.1% өсөлттэй 1,904.30 ам.доллар болоод байна. Пүрэв гарагт алтны ханш 2021 оны 6 сарын 11 хойш анх удаа 1,900 ам.доллар давж 1.8% өссөн бөгөөд шинжээчид нөхцөл байдал үргэлжлэн хурцадвал алтны ханш өссөөр байх хүлээлттэй байна.

Зэсийн зах зээл

Нөөцийн бууралт болон ОХУ-д хориг тавьж магадгүй төлөв байдал зах зээлд никелийн ханшийг 3 долоо хоног хагасын дээд цэгт аваачсан бол зэсийн үнэ мөн өслөө. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.4% өсөж 9,965.50 ам.долларт арилжаалагдах зуур Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн фьючерс 0.2% дээшлэн 71,490 юань болж өслөө. Японы дотоодын болон экспортын зэс кабелийн борлуулалт 1-р сард өмнөх оны мөн үеэс 0.5% өсөж 50,800 тонн хүрчээ.

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1367	0.05%		
USD/CNY	6.333	-0.07%		
USD/RUB	76.3176	0.01%		
USD/JPY	115.16	0.19%		
USD/KRW	1196.25	-0.08%		
AUD/USD	0.7198	-0.02%		
GBP/USD	1.3607	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	34312.0	-1.78%		
S&P 500	4380.3	-2.12%		
NASDAQ	13716.7	-2.88%		
FTSE 100	7537.4	-0.87%		
Nikkei 225	27094.2	-0.51%		
DAX	15267.6	-0.67%		
Hang Seng	24646.2	-0.59%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1890.82	-0.40%		
Мөнгө	23.83	-0.02%		
Нүүрс (Чин хуанг дао)	166.59	0.00%		
Зэс (LME)	9929	-0.64%		
Төмрийн хүдэр	683.50	-1.58%		
Газрын тос (NYME)	91.15	-0.66%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.14%	14.20%		
US 3M LIBOR	0.49%	4.15%		
US 6M LIBOR	0.79%	-0.70%		
US 12M LIBOR	1.33%	-0.96%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.98%	1.06%		
UK Treasury 10Y	1.46%	-4.00%		
GE Treasury 10Y	0.23%	-16.30%		
JP Treasury 10Y	0.22%	-2.21%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.06%	0.06%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.31%	0.03%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.58%	-0.17%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.96%	0.00%
ММС	9.25%	4/15/2024	23.80%	1.34%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.35%	0.00%
Номад	5.13%	4/7/2026	4.71%	-0.01%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.96%	-0.01%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.39%	-0.06%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.05%	-0.02%

Хувьцаа Ханш 24ц өөрч.

Turquoise Hill Resources	20.53	-2.19%
Mongolian Mining Corp	2.1	0.00%
Erdene Resource Dev	0.45	-2.20%
Centerra Gold	11.51	1.86%

Макро эдийн засаг (Монгол) Огноо Дүн

Инфляцийн түвшин	2022 (I)	14.6%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал

Валют Q1 22 Q2 22 Q3 22 Q4 22 2023

EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд

Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн Үр дүн Таам. Өмнөх

JP Trade Balance Total Yen	-2191B	-1607B	-582.4B
JP Imports YY	39.6%	37.1%	41.1%
JP Exports YY	9.6%	16.5%	17.5%
JP Machinery Orders YY	5.1%	0.6%	11.6%
JP Machinery Orders MM	3.6%	-1.8%	3.4%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ Цаг Таам. Өмнөх

UK Retail Sales YY	14:00	8.7%	-0.9%
UK Retail Sales MM	14:00	1.0%	-3.7%
US Existing Home Sales	23:00	6.1M	6.18M
JP CPI, Overall Nationwide	7:30	-	0.8%
JP CPI, Core Nationwide YY	7:30	0.3%	0.5%

Маргааш хүлээгдэж буй мэдээ Цаг Таам. Өмнөх

UK Flash Manufacturing PMI	17:30	-	57.3
FR Markit Mfg Flash PMI	16:15	-	55.5
GE Markit Mfg Flash PMI	16:30	-	59.8
JP Jibun Bank Mfg Flash PMI	8:30	-	55.4

Газрын тосны зах зээл

Газрын тосны үнэ дахин буурч эхэллээ. Өчигдөр үнэ өсөж байсан ч өнөөдөр буурсан байна. Иран улс дэлхийн тэргүүлэгч улсуудтай тохиролцоонд хүрч чадвал газрын тосны нийлүүлэлт үлэмж нэмэгдэх тул ханш буурсан байна. Brent газрын тосны үнэ 0.68 цент унаж 92.29 ам.доллар орчимд арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

Баасан гарагт маш урт хугацааны Японы засгийн бондуудын өгөөж ухарлаа. Украины эргэн тойронд асуудал хурцдсаар байгаа нь эрсдэл багатай хөрөнгийн эрэлтийг нэмэгдүүлж, 3 гаруй жилийн хугацаанд хамгийн босоо өнцөгтэй байсан өгөөжийн муруй нь хавтгайрлаа. 30 жилийн хугацаатай өгөөж өмнөх арилжааны өдөр хүрсэн 6 жилийн дээд түвшин 0.995%-иас 3 нэгж буурч 0.96% болсон байна. 10 жилийн өгөөж өнгөрсөн долоо хоногт 0.23% хүртэл өсөөд байсан бол Төв банкны мэдэгдлийн дараа 0.2% болтлоо ухарсан. Гэхдээ Пүрэв гарагт 0.225% хүртлээ буцаж одоогоор 0.22% болоод байна.

Хөрөнгийн зах зээл

ОХУ болон АНУ нар Украины асуудлаар ирэх долоо хоногт Европт уулзаж хэлэлцэхээр болсон байна. Энэ мэдээний дараа хөрөнгийн зах зээлд өсөлтүүд гарч эхэллээ. S&P500, Nasdaq100 индексүүд өсөж, Азийн зах зээл уналтаас эргэн ногоорч эхэллээ. Өчигдөр хувьцааны ханш хүчтэй унаж байсан бол өнөөдөр эсрэг хөдөлгөөн хүчтэй явж байна.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдлад ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.